



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 54

Номгон

**Дуутай хурууны наадгайг соёлын өвд  
бүртгүүлэх ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.12, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.42 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ард түмний дунд үе дамжин өвлөгдөж ирсэн “Дуутай хуруу” хэмээх уламжлалт наадгайг НҮБ-ын “Юнеско”-ийн соёлын биет бус өвд бүртгүүлэхээр ирүүлсэн Эрдэнэцогт сумын иргэдийн саналыг сайшаан дэмжсүгэй.

2. “Дуутай хуруу” уламжлалт наадгайн гарал үүсэл, түүхэн уламжлалыг илтгэсэн баримт материалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, соёлын өвд бүртгүүлэх үүрэг бүхий ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Баясгалангомбо-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Төмөрбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч, Эрдэнэцогт сумын Засаг дарга

М.Мөнхбат-Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга

С.Баярмагнай-Аймгийн Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны дарга

С.Үнэнбуян-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Д.Цэдэнсодном-Өлзийт сумын Засаг дарга

Д.Батбаатар-Баян-Овоо сумын Засаг дарга

3. Зөвхөн Баянхонгор аймгийн цөөн хэдэн сумдад өвлөгдөж ирсэн “Дуутай хуруу” өвөрмөц наадгайг соёлын биет бус өвд бүртгүүлж өгөхийг Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамны Соёлын газарт уламжилсугай.

116783

4. “Дуутай хуруу” наадгайн төрлийг “Юнеско”-ын дэлхийн Соёлын биет бус өвд бүртгүүлэхэд арга зүй, удирдлагаар хангаж, бэлтгэл зохион байгуулалтад гарах зардлыг санхүүжүүлж, дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР